



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/300

Булган сум

### Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны Х1Х/08 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээний 50,000,000 (тавин сая) төгрөгийг захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д олгосугай.

2.Доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд зарцуулах, эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардлагатай хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын "Доройтсон хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх ногоон байгууламжийг нэмэгдүүлэх" төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

